



**ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН
ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/022

Улаанбаатар хот

**Түншлэлийн төслийн бэлтгэл
ажлын төлбөрийн хувь хэмжээ болон
төлбөр тогтоох аргачлалын тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 20.1.10, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.3, Засгийн газрын 2023 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан “Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавих журам”-ын 3.1.3, 3.4, 3.5 дахь заалт, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1455 дугаартай албан бичиг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 6.7.2, 6.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон бусад хууль, журмын дагуу Түншлэлийн төсөл хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Түншлэлийн төслийн бэлтгэл ажлын төлбөрийн хувь хэмжээ болон төлбөр тогтоох аргачлалыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлбөр, аргачлалыг Хууль зүй, дотоод хэргийн яамны улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэний дараа сараас дагаж мөрдсүгэй.

3. Аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, мөрдүүлэн ажиллахыг Захиргаа, санхүүгийн газар (Д.Цоож)-т, үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



М.АМГАЛАНБААТАР

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв
ТӨААТҮГ-ын захирлын 2022 оны 05 дугаар
сарын 21-ны өдрийн А/02 дугаар тушаалын
хавсралт



Түншлэлийн төслийн бэлтгэл ажлын төлбөрийн
жишиг хувь хэмжээ болон төлбөр тогтоох аргачлал

№	Ангилал	Төсөвт өртөр /төг/	Жишиг хувь хэмжээ	
			Урьдчилсан үнэлгээ	Бүрэн шинжилгээ
1	Нийтийн зориулалттай дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэх төсөл	10 тэрбум хүртэл	Аргачлалаар	3.0%
		100 тэрбум хүртэл		1.0%
		100 тэрбумаас дээш		0.7%

№	Ангилал	Төсөвт өртөр /төг/	Жишиг хувь хэмжээ	
			Урьдчилсан үнэлгээ	Бүрэн шинжилгээ
1	Төрийн үйлчилгээний салбарт хэрэгжүүлэх төсөл	10 тэрбум хүртэл	Аргачлалаар	3.0%
		100 тэрбум хүртэл		1.0%
		100 тэрбумаас дээш		0.7%

Урьдчилсан үнэлгээний ажлын төлбөр тооцох аргачлал:

Тухайн ажилтны үндсэн цалин

1 цагийн дундаж цалин /ДЦ/ = -----

Тухайн сарын ажлын цаг

1 илүү цагийн дундаж цалин /ИДЦ/ = (1 цагийн дундаж цалин)*1.5

Урьдчилсан үнэлгээний төлбөр = ДЦ*(аж.цаг)*(гиш.тоо)+ИДЦ(аж.цаг)*(гиш.тоо)

Тайлбар: Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санаачилсан төсөл дээр урьдчилсан үнэлгээний төлбөр тооцохгүй.